

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/045/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: [tserenkhandd@audit.gov.mn](mailto:tserenkhandd@audit.gov.mn)

Аудитор: Л.Отгон

Утас: 99059489 Цахим хаяг: [devjikhcapital.audit@gmail.com](mailto:devjikhcapital.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/045/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govial:ai@audit.gov.mn

2025.02.24 № 87

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.НАСАНБУЯН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн еөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс сумын 100 жилийн ойгоор хүндэтгэл үзүүлэхэд 3,850.0 мянган төгрөгийг зарцуулсан,;
- Цахим дэлгүүрээс 21,061.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан авалт хийгээгүй;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс спортын арга хэмжээний зардалд 3422.0 мянган төгрөг, малчдад 4,900.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна;

8225020222

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиож аймгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламжид 75,952.5 мянган төгрөгийг зарцуулсан.

Иргэд, байгууллагаас 469,155.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 17,217.0 мянган төгрөгийн бараа материал хандиваар үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

"Нээлттэй Алтай" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар шинээр гэр бүл болсон 12 залуу малчин өрхөд тус бүр 50 толгой ямаа олгож, малжуулах ажлыг зохион байгуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 104 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас нийт дүнгээр 93.4 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Б.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>57,373,180.00</b>	<b>94,965,233.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,828,701.00</b>	<b>-</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,828,701.00</b>	<b>-</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,828,701.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>55,544,479.00</b>	<b>94,965,233.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>36,064,479.00</b>	<b>75,485,233.00</b>
35410	Бичиг хэргийн материал	90,000.00	200,000.00
35420	Аж ахуйн материал	21,337,733.00	62,869,733.00
35440	Түлш, шатах тослох материал	4,926,746.00	3,666,000.00
35470	Бусад хангамжийн материал	9,710,000.00	8,749,500.00
35600	Мал амьтад	19,480,000.00	19,480,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,063,169,140.46</b>	<b>3,514,562,205.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,063,169,140.46</b>	<b>3,514,562,205.74</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,970,373,140.46</b>	<b>3,441,266,205.74</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,422,180,659.57	1,651,278,419.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(489,633,708.07)	(595,509,384.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,484,800.00	312,144,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(83,406,666.77)	(51,212,433.28)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	114,121,276.00	143,588,076.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,431,931.99)	(92,855,523.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,272,200.00	152,402,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,102,905.13)	(49,322,402.78)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	36,888,000.00	95,488,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	938,972,847.71	1,707,372,847.71
39215	Хуримтлагдсан элэгдэл	(62,971,430.86)	(128,160,272.23)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>92,796,000.00</b>	<b>73,296,000.00</b>
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,050,000.00)	(1,050,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	92,796,000.00	73,296,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,120,542,320.46</b>	<b>3,609,527,438.74</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>26,655,300.00</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>26,655,300.00</b>	<b>-</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>26,655,300.00</b>	<b>-</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>26,655,300.00</b>	<b>-</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	25,775,300.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	880,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,093,887,020.46</b>	<b>3,609,527,438.74</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,093,887,020.46</b>	<b>3,609,527,438.74</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	327,231,867.50	327,231,867.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	327,231,867.50	327,231,867.50
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,599,275,209.21</b>	<b>3,114,915,627.49</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,012,206,276.96	1,579,775,209.21
51220	Тайлант үеийн үр дүн	587,068,932.25	1,535,140,418.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,379,943.75	167,379,943.75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,120,542,320.46</b>	<b>3,609,527,438.74</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**(төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,402,598,729.00</b>	<b>2,848,499,744.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>709,336,925.00</b>	<b>1,643,967,860.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>709,336,925.00</b>	<b>1,643,967,860.80</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	708,962,925.00	1,626,490,860.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	374,000.00	17,477,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,261,804.00</b>	<b>1,204,531,884.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>146,596,604.00</b>	<b>217,519,884.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,556,604.00	217,519,884.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>546,665,200.00</b>	<b>987,012,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	546,665,200.00	987,012,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>815,529,796.75</b>	<b>1,296,859,326.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>815,529,796.75</b>	<b>1,296,859,326.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>783,629,918.12</b>	<b>1,244,471,538.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>342,454,698.03</b>	<b>600,238,737.37</b>
210101	Үндсэн цалин	193,729,707.11	268,840,261.07
210102	Нэмэгдэл	95,320,625.87	209,512,925.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,048,599.05	48,460,000.00
210104	Урамшуулал	38,355,766.00	73,425,550.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,453,257.43</b>	<b>75,368,379.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,012,157.43	53,688,379.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,860,300.00	5,420,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,200.00	2,710,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	572,100.00	2,710,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,720,500.00	10,840,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,402,301.35</b>	<b>28,019,032.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,230,207.35	3,966,286.07
210302	Түлш, халаалт	26,124,094.00	24,008,746.00
210303	Цэвэр, бохир ус	48,000.00	44,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>62,883,270.00</b>	<b>65,408,257.00</b>
210401	Бичиг хэрэг	3,275,700.00	4,624,400.00
210402	Тээвэр, шатахуун	49,277,810.00	53,238,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,627,510.00	1,778,157.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,099,750.00	2,192,650.00

Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,602,500.00	3,455,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>457,500.00</b>	<b>1,935,000.00</b>
210502	Хоол, хүнс	457,500.00	945,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,238,500.00</b>	<b>16,595,400.00</b>
210602	Тавилга	34,796,500.00	-
210604	Урсгал засвар	9,442,000.00	16,595,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>23,520,000.00</b>	<b>22,188,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	23,520,000.00	22,188,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51,863,919.96</b>	<b>4,795,837.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,230,250.00	2,147,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	664,350.00	244,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,847.96	199,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	1,117,000.00
210807	Газрын төлбөр	354,472.00	465,227.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>185,356,471.35</b>	<b>429,922,895.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,893,550.00	186,852,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	143,462,921.35	242,990,295.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,899,878.63</b>	<b>52,387,788.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,442,036.00</b>	<b>25,367,852.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,463,036.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,979,000.00	1,800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>11,457,842.63</b>	<b>27,019,936.50</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,441,840.23	27,019,052.50
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,002.40	884.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>587,068,932.25</b>	<b>1,551,640,418.10</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>587,068,932.25</b>	<b>1,535,140,418.28</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>693,261,804.00</b>	<b>1,204,531,884.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,261,804.00</b>	<b>1,204,531,884.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>146,596,604.00</b>	<b>217,519,884.00</b>
131101	Төрийн болон орсон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,556,604.00	217,519,884.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,000.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>546,665,200.00</b>	<b>987,012,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	546,665,200.00	987,012,000.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>647,291,182.40</b>	<b>1,100,639,384.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>647,291,182.40</b>	<b>1,100,639,384.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>615,391,303.77</b>	<b>1,048,251,595.50</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>342,454,698.03</b>	<b>600,238,737.37</b>
210101	Үндсэн цалин	193,729,707.11	268,840,261.07
210102	Нэмэгдэл	95,320,625.87	209,512,925.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,048,599.05	48,460,000.00
210104	Урамшуулал	38,355,766.00	73,425,550.87
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,281,958.43</b>	<b>73,539,678.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,840,858.43	51,859,678.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,860,300.00	5,420,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,200.00	2,710,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	572,100.00	2,710,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,720,500.00	10,840,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,837,157.35</b>	<b>33,449,336.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,079,157.35	4,117,336.07
210302	Түлш, халаалт	16,710,000.00	29,288,000.00
210303	Цэвэр, бохир ус	48,000.00	44,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,939,020.00</b>	<b>80,822,507.00</b>
210401	Бичиг хэрэг	3,265,700.00	4,734,400.00
210402	Тээвэр, шатахуун	35,376,060.00	67,207,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,627,510.00	1,778,157.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,792,250.00	3,432,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,877,500.00	3,550,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>457,500.00</b>	<b>1,935,000.00</b>
210502	Хоол, хүнс	457,500.00	945,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,238,500.00</b>	<b>20,470,400.00</b>
210602	Тавилга	34,796,500.00	-
210604	Урсгал засвар	9,442,000.00	16,595,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>22,640,000.00</b>	<b>23,068,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	22,640,000.00	23,068,000.00

Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,863,919.96	4,795,837.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,230,250.00	2,147,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	664,350.00	244,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,847.96	199,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	1,117,000.00
210807	Газрын төлбөр	354,472.00	465,227.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,678,550.00	209,932,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,678,550.00	209,852,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,899,878.63	52,387,788.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,442,036.00	25,367,852.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,463,036.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,979,000.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,457,842.63	27,019,936.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,441,840.23	27,019,052.50
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,002.40	884.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	45,970,621.60	103,892,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	45,970,621.60	103,892,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,970,621.60	103,892,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,970,621.60	103,892,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,970,621.60	103,892,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(45,970,621.60)	(103,892,500.00)

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,231,867.50	167,379,943.75	1,012,206,276.96	1,506,818,088.21
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,231,867.50	167,379,943.75	1,012,206,276.96	1,506,818,088.21
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,231,867.50	167,379,943.75	1,599,275,209.21	2,093,887,020.46
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	327,231,867.50	167,379,943.75	1,599,275,209.21	2,093,887,020.46
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,231,867.50	167,379,943.75	1,579,775,209.21	2,074,387,020.46
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	327,231,867.50	167,379,943.75	3,114,915,627.49	3,609,527,438.74

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**(төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>987,012,000.00</b>	<b>959,992,947.50</b>	<b>27,019,052.50</b>	<b>97.26</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>987,012,000.00</b>	<b>959,992,947.50</b>	<b>27,019,052.50</b>	<b>97.26</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>961,110,000.00</b>	<b>934,625,095.50</b>	<b>26,484,904.50</b>	<b>97.24</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>613,567,000.00</b>	<b>600,238,737.37</b>	<b>13,328,262.63</b>	<b>97.83</b>
210101	Үндсэн цалин	352,234,200.00	268,840,261.07	83,393,938.93	76.32
210102	Нэмэгдэл	163,333,200.00	209,512,925.43	(46,179,725.43)	128.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,000,000.00	48,460,000.00	3,540,000.00	93.19
210104	Урамшуулал	45,999,600.00	73,425,550.87	(27,425,950.87)	159.62
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,740,000.00</b>	<b>73,539,678.06</b>	<b>3,200,321.94</b>	<b>95.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,060,000.00	51,859,678.06	3,200,321.94	94.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,420,000.00	5,420,000.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,710,000.00	2,710,000.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,710,000.00	2,710,000.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,840,000.00	10,840,000.00	0.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,810,000.00</b>	<b>33,449,336.07</b>	<b>2,360,663.93</b>	<b>93.41</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,100,000.00	4,117,336.07	1,982,663.93	67.50
210302	Түлш, халаалт	29,630,000.00	29,288,000.00	342,000.00	98.85
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	44,000.00	36,000.00	55.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>76,490,000.00</b>	<b>76,480,107.00</b>	<b>9,893.00</b>	<b>99.99</b>
210401	Бичиг хэрэг	4,740,000.00	4,734,400.00	5,600.00	99.88
210402	Тээвэр, шатахуун	61,300,000.00	61,414,900.00	(114,900.00)	100.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,778,157.00	21,843.00	98.79
210404	Ном, хэвлэл	150,000.00	120,000.00	30,000.00	80.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,432,650.00	67,350.00	98.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>2,170,000.00</b>	<b>1,935,000.00</b>	<b>235,000.00</b>	<b>89.17</b>
210502	Хоол, хүнс	1,170,000.00	945,000.00	225,000.00	80.77
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,700,000.00</b>	<b>37,656,400.00</b>	<b>43,600.00</b>	<b>99.88</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,100,000.00	18,017,000.00	83,000.00	99.54
210602	Тавилга	3,000,000.00	3,044,000.00	(44,000.00)	101.47

Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	16,600,000.00	16,595,400.00	4,600.00	99.97
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>26,400,000.00</b>	<b>23,068,000.00</b>	<b>3,332,000.00</b>	<b>87.38</b>
210702	Дотоод албан томилолт	26,400,000.00	23,068,000.00	3,332,000.00	87.38
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,653,000.00</b>	<b>4,628,837.00</b>	<b>24,163.00</b>	<b>99.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	1,980,800.00	19,200.00	99.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,000.00	244,350.00	650.00	99.73
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	199,460.00	540.00	99.73
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,000.00	1,117,000.00	3,000.00	99.73
210807	Газрын төлбөр	466,000.00	465,227.00	773.00	99.83
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>87,580,000.00</b>	<b>83,629,000.00</b>	<b>3,951,000.00</b>	<b>95.49</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,500,000.00	83,549,000.00	3,951,000.00	95.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	80,000.00	0.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,902,000.00</b>	<b>25,367,852.00</b>	<b>534,148.00</b>	<b>97.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,902,000.00</b>	<b>25,367,852.00</b>	<b>534,148.00</b>	<b>97.94</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,102,000.00	23,567,852.00	534,148.00	97.78
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>987,012,000.00</b>	<b>959,992,947.50</b>	<b>27,019,052.50</b>	<b>97.26</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>987,012,000.00</b>	<b>959,992,947.50</b>	<b>27,019,052.50</b>	<b>97.26</b>
320001	Орон нутгийн төсвөөс	987,012,000.00	959,992,948.50	27,019,051.50	97.26
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>26</b>	<b>22</b>	<b>4</b>	<b>-</b>
620001	Удирдах ажилтан	9	9	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	8	6	2	-
620003	Үйлчлэх ажилтан	6	5	1	-
620004	Гэрээт ажилтан	3	2	1	-

**2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>217,519,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>217,519,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	217,519,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,942,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,792,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000,000.00</b>
210602	Тавилга	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>567,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	567,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>206,009,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	206,009,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>217,519,884.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>217,519,884.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	217,519,884.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 24,200.0 төгрөгийн алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

### Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Бусад биет бус хөрөнгө 19,500.0 мянган төгрөгийг дотооддоо шилжүүлэн авснаар тайлагнаагүй, Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 4,700.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд зардалд тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Аудитаар нийт 95,506.4 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрч 3,850,0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 89,827.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1,828.7 мянган төгрөгийн 1 заалт зөвлөмж хүргүүлээ.

### Төлбөрийн акт

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс сумын 100 жилийн ойгоор хүндэтгэл үзүүлэх зорилгоор 3,850.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч бэлэглэсэн.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

### Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс бэлэг дурсгал, уралдаан тэмцээнд 7,922.0 мянган төгрөгийн, малчдад ботгоны урамшуулалд 4,900.0 мянган төгрөгийн, төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвөөс 100 жилийн ойн дэмжлэгт олгосон санхүүжилтээс сумын ойн хүндэтгэлийн цайллагад 55,944.7 мянган төгрөгийн 68,766.7 мянган төгрөгийн үр дүнгүй зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Цахим дэлгүүрээс 21,061.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авахгүй байж, биелэлтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тайлант онд цалингийн нөхөн олговрын авлага 1,828.7 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнаагүй, нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Шүүхийн шийдвэрээр 1,828.7 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна.

Өгсөн зөвлөмж: Төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллах

**Говь-Алтай аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Цээл сумын Засаг даргын Тамгын газар	2	24,200.0	-	-	2	24,200.0	2	24,200.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24,200.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>24,200.0</b>	<b>2</b>	<b>24,200.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цээл сумын Засаг даргын Тамгын газар	4	95,506.4	1	3,850.0	2	89,827.7	1	1,828.7	-	-	-	-
	<b>4</b>	<b>95,506.4</b>	<b>1</b>	<b>3,850.0</b>	<b>2</b>	<b>89,827.7</b>	<b>1</b>	<b>1,828.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/ мянган төгрөгөөр/							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	
Бусад хууль тогтоомжтой хслбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	<b>НИЙТ</b>		1				1		